# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
# ТОГТООЛ

2018 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 380

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 57.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50.9-д тус тус заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Онцгой байдлын байгууллагын алба хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлэж байхыг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2006 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 104 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолыг 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд У.ХҮРЭЛСҮХ

Монгол Улсын Шадар сайд Ө.ЭНХТҮВШИН

Засгийн газрын 2018 оны 380 дугаар
тогтоолын хавсралт

## ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИД АЛБАН АЖЛЫН ОНЦГОЙ НӨХЦӨЛИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Онцгой байдлын байгууллагын алба хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгоход энэхүү журмыг мөрдөнө.

2. Онцгой байдлын байгууллагын алба хаагчид алба хаах хугацаанд нь албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгоно.

3. Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг тухайн алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувиар тооцож, сар бүр олгоно.

4. Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг Онцгой байдлын байгууллага жил бүрийн төсөвтөө тусгана.

------o0o-----